

**НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөр 2010 онд хэлэлцүүлэх Монгол Улс дахь  
Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний илтгэл бэлтгэх Ажлын  
хэсгийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө**

№	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Ажлын хэсгийн анхдугаар уулзалтыг зохион байгуулж, илтгэлийн төсөл бэлтгэх хуваарь, илтгэлд тусгах, дэвшүүлэх асуудлын чиглэлийг тодорхойлох	2009 оны III улиралд	Нарийн бичгийн дарга
2.	Үндэсний илтгэлд тусгах асуудлын талаар ТББ-ын саналыг авах зорилгоор хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын Үндэсний зөвлөлгөөн зохион байгуулах	2009 оны XI сард багтаан	ХЗДХЯ
3.	Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний илтгэл бэлтгэхтэй холбогдуулан НҮБ-ын ХЭДКГ-ын дэмжлэгтэйгээр сонирхогч талуудыг оролцуулсан семинарыг Улаанбаатар хотноо зохион байгуулах	2010 оны I улиралд	ГХЯ
4.	Хүний эрхийн Зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаанаар Үндэсний илтгэлийг хэлэлцэж буй явц, хуралдааны дэг жаяг, ерөнхий байдалтай газар дээр нь нэг удаа танилцаж, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах	2009 оны IV улиралд	Ажлын хэсэг
5.	Үндэсний илтгэл бэлтгэхтэй холбогдох гарах зардал, төсөв (томилолт, судалгаа, орчуулга, бичиг хэрэг гэх мэт)-ийг гаргаж, ХЗДХСайдын 2010 оны багцад суулгах	2009 оны IV улиралд	Ажлын хэсэг
6.	Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх гарч болзошгүй асуудлуудыг тодорхойлж, холбогдох байгууллагуудаас судалгаа гаргуулах	2010 оны эхний хагас жилд	Ажлын хэсэг
7.	Ажлын хэсгийн 2 дахь уулзалтыг зохион байгуулж, илтгэлийн эхний хувилбарыг хэлэлцүүлж, санал солилцох	2010 оны 2 дугаар сард	Нарийн бичгийн дарга
8.	Ажлын хэсгийн 3 дахь уулзалтыг зохион байгуулж, илтгэлийн хоёрдахь хувилбарыг хэлэлцэж, санал солилцох	2010 оны 4 дүгээр сард	Нарийн бичгийн дарга
9.	Үндэсний илтгэлийн төслийн талаар холбогдох яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах	2010 оны 5 дугаар сарын 15-ны дотор	Ажлын хэсэг
10.	Үндэсний илтгэлийг англи хэлээр орчуулж бэлэн болгох	2010 оны 6 дугаар сарын 20-ны дотор	Ажлын хэсэг
11.	Үндэсний илтгэлийг Ажлын хэсэг, Хүний эрхийн Зөвлөлийн хуралдааны үеэр тус тус хамгаалах Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг Засгийн газраар батлуулах	2010 оны 4 дүгээр сарын 15-ны дотор	Ажлын хэсэг
12.	Үндэсний илтгэлийг Хүний эрхийн Зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх	2010 оны 7 дугаар сард багтаан	Ажлын хэсэг